



ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2018 оны 12 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар _____ / _____

Улаанбаатар хот

Энэхүү санамж бичгийг нэг талаас улсын бүртгэлийн 9104399 дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж-1, Бага тойрууд байрлах Монгол Улсын Их Сургууль /цаашид "МУИС" гэх/, түүнийг төлөөлж МУИС-ийн захирал Я.Төмөрбаатар, нөгөө талаас улсын бүртгэлийн 9072004122 дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороолол, 11-р хороо, Ногоон нуурын гудамж-101, Pro ONE оффис-503 тоотод байрлах Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл /цаашид "МСНЭ", хамтад нь "Талууд" гэх/, түүнийг төлөөлж МСНЭ-ийн ерөнхийлөгч Х.Мандахбаяр нар үйл ажиллагааны зорилго, зорилгод үндэслэн харилцан тохиролцож, хамтран ажиллахаар байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү санамж бичгийн зорилго нь талууд талууд хоорондын түншлэлийг хөгжүүлэх, судалгаа шинжилгээний ажил, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, оюутан дадлагажуулах, удирдлага, ажилтнуудыг чадавхжуулах сургалтанд хамруулах, мэдээлэл солилцоход үр ашигтай хамтран ажиллах явдал юм.
- 1.2 Талууд хамтын ажиллагаандаа хуулийг дээдлэх, харилцан бие биенээ хүндэтгэн, байгууллагууд хоорондын харилцааны хэм хэмжээнд үндэслэн бүтээгчээр хамтран ажиллах зарчмыг баримтална.
- 1.3 Хамтран ажиллах санамж бичгийн үндсэн чиглэлүүдээр тодорхой ажлуудыг гүйцэтгэхэд тухай бүр харилцан тохиролцох замаар гэрээ байгуулан гүйцэтгэнэ.

Хоёр. Хамтран ажиллах чиглэл

- 2.1 МУИС нь үндэсний болон нийтийн сайн сайхны төлөө нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн эрүүл зөв сэтгүүл зүйг хөгжүүлэх талаар МСНЭ-ээс зохион байгуулж буй ажлуудад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах.
- 2.2 Талууд хамтран сэтгүүлчдийн үр чадвар, чадавхыг дээшлүүлэх чиглэлээр давтан сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах.
- 2.3 Хамтын үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг талууд өөрсдийн цахим хуудсанд байршуулах, тогтмол шинэчлэх.
- 2.4 МСНЭ-тэй хамтын ажиллагаатай дотоод, гадаадын хэлэлц мэдээллийн байгууллага, их дээд сургуулийн хамтын ажиллагаа, солилцооны хөтөлбөрт МУИС-ийн Сэтгүүл зүй, олон

- нийтэй харилцах тэнхимийн багш, тухайн чиглэлийн ажилтан, алба хаагчид хамрагдахад мэдээлэл, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх.
- 2.5 МУИС-ийн сэтгүүл зүйн салбарын оюутнуудыг МСНЭ болон түүний хамтрагч байгууллагуудад дадлага хийлгэх нөхцлийг бүрдүүлэх.
- 2.6 Хамтын ажиллагаанд хамаарал бүхий ажлаар аль нэг талын зохион байгуулж байгаа гадаад, дотоодын арга хэмжээ, сургалт, хэлэлцүүлэгт талуудын төлөөллийг оролцуулах.
- 2.7 Талуудын зохион байгуулж буй маркетинг, олон нийтийн арга хэмжээнд хамтран оролцох.

Гурав. Хамтын ажиллагаанд талуудын хүлээх үүрэг

- 3.1 Талууд хамтын ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа арга хэмжээ зохион байгуулахдаа урьдчилан харилцан мэдээлэл өгөх, хамтран оролцох зарчмыг баримтална.
- 3.2 Талууд хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийн хариуцлага харилцан аль нэг талындаа өмнө хүлээхгүй бөгөөд өөрсдийн боломжид тулгуурлан харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 3.3 Санамж бичигт дурдсан ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлэх үүргийг харьяалах чиглэлийн дагуу Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монгол Улсын Их Сургуулийн Ажлын алба хүлээнэ.
- 3.4 Талууд угирал тутамд хамтын ажиллагааны талаар уулзалт, ярилцлага зохион байгуулж, ажлаа дүгнэж удирдлагадаа танилцуулж байна.

Дөрөв. Бусад нөхцөл

- 4.1 Санамж бичигт дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг талууд хамтран боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 4.2 Санамж бичгийг 2018 оны 12 дугаар сарын 4-нөөс 2021 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хүртэл 3 жилийн хугацаатай байгуулав. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Санамж бичгийн хугацааг сунгаж болно.
- 4.3 Талууд энэхүү Санамж бичгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй буюу зохих ёсоор биелүүлэхгүй тохиолдолд, түүнчлэн Санамж бичгийг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөгдөөн, маргааныг зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 4.4 Энэхүү Санамж бичиг нь Талууд тус бүрийн залгамжлагч аливаа этгээдэд нэгэн адил хамаарна.
- 4.5 Энэхүү Санамж бичигт талууд гарын үсэг зурж, тамга дарж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 4.6 Талууд Санамж бичгийг 2 хуви үйлдэж, тус бүрдээ хадгалах бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН.

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН



МОНГОЛЫН СЭТГҮҮЛЧДИЙН НЭГДСЭН
ЭВЛЭЛИЙН ЕРӨНХИЙЛЭГЧ

